



128

НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2011 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

“HI SEOUL” бүх нийтийн гүйлтийн
тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Нийслэл Улаанбаатар хот үүсч байгуулагдсаны 372 жилийн ойд зориулан Улаанбаатар-Сөүл хотын ах дүүгийн хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулах “HI SEOUL” бүх нийтийн гүйлтийн тэмцээнийг 2011 оны 09 дүгээр сарын 24-ны өдөр Их жанжин Сүхбаатарын талбайд зохион байгуулсугай.

Хоёр. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Тэмцээнийг зохион явуулахад шаардагдах 2.625.750 /хоёр сая зургаан зуун хорин таван мянга долоон зуун тавин/ төгрөгийг арга хэмжээний зардлаас гаргахыг нягтлан бодогч Ж.Цэдэнсодномд зөвшөөрсүгэй.

Дөрөв. Тэмцээний бэлтгэл ажлыг урьдчилан хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг ахлах мэргэжилтэн А.Болдмаад үүрэг болгосугай.

ДАРГА




Ж.ГАНБОЛД

МУОНСОН-2011

1110500101

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2011 оны *ес* дүгээр сарын *23* -ны өдрийн
А/4 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт.



"HI SEOUL" БҮХ НИЙТИЙН ГҮЙЛТИЙН
ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Нийт дүн
1.	Шүүгчдийн хөлс 27 хүн х 15.000 төг = 405.000 1 хүн х 30.000 төг = 30.000	435.000
2.	Өргөмжлөл, батламж 22ш х 3500₮	77.000
3.	Медаль 22ш х 5000₮	110.000
4.	Анонс хэвлүүлэх 22.75м ² х 5000.=.113 750 18м ² х 5000.=.90.000	203.750
5.	Тайз, техник хэрэгслэл /1өдөр/	500.000
6.	Унааны зардал /техник хэрэгсэл зөөх/	100.000
7.	Энгэрийн номер 1000ш х 1200₮	1.200.000
	Нийт дүн	2.625.750

Нийслэлийн Биеийн тамир спортын газрын даргын
2011 оны ес дүгээр сарын 13-ны өдрийн
1/12 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт.

"HI SEOUL" БҮХ НИЙТИЙН ГҮЙЛТЫН ТЭМЦЭЭНИЙ
ШҮҮГЧДИЙН БҮРЭЛДХҮҮН

№	Овог нэр	Хаана ямар ажил	Гүйцэтгэсэн
1	Б.Түвшинбаяр	МХАХ	Ерөнхий шүүгч
2	А.Амгалан	МХАХ	Нарийн бичиг шүүгч
3	Б.Болд	МХАХ	Аж ахуйн шүүгч
4	Н.Дэмбээ	МХАХ	Аж ахуйн шүүгч
5	Б.Дэмбрэл	МХАХ	Цагчин шүүгч
6	С.Очирбат	МХАХ	Цагчин шүүгч
7	Ө.Нямсайхан	МХАХ	Цагчин шүүгч
8	Б.Буянхишиг	МХАХ	Гарааны шүүгч
9	Б.Ган-Эрдэнэ	МХАХ	Гарааны шүүгч
10	С.Цогтбаяр	МХАХ	Барианы шүүгч
11	Ж.Мөнхбат	МХАХ	Барианы шүүгч
12	Б.Батсайхан	МХАХ	Барианы шүүгч
13	Ж.Эрдэнэ	МХАХ	Барианы шүүгч
14	Г.Энхээ	МХАХ	Барианы шүүгч
15	Н.Баяр	Оюутан	Туслах шүүгч
16	Т.Энхжин	Оюутан	Туслах шүүгч
17	Т.Аззаяа	Оюутан	Туслах шүүгч
18	Б.Гантуяа	Оюутан	Туслах шүүгч
19	Б.Мөнхжин	Оюутан	Туслах шүүгч
20	Г.Гансүх	Оюутан	Туслах шүүгч
21	Х.Хүслэн	Оюутан	Туслах шүүгч
22	Ө.Мөнх-Эрдэнэ	Оюутан	Туслах шүүгч
23	О.Бямбасайхан	Оюутан	Туслах шүүгч
24	М.Ганбат	Оюутан	Туслах шүүгч
25	Ш.Соёлзул	МХАХ	Нэвтрүүлэгч
26	Б.Гүнбилэг	эмч	Эмч шүүгч
27	С.Дөлгөөн	эмч	Эмч шүүгч
28	С.Ариунаа	эмч	Эмч шүүгч

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Ц.ЦОГЗОЛМАА



**НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТ ҮҮСЧ БАЙГУУЛАГДСАНЫ 372 ЖИЛИЙН ОЙД
ЗОРИУЛАН УЛААНБААТАР- СӨҮЛ ХОТЫН АХ ДҮҮГИЙН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ "HI SEOUL"
БҮХ НИЙТИЙН ГҮЙЛТИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

Нийслэл Улаанбаатар хот үүсч байгуулагдсаны 372 жилийн ойд зориулан Улаанбаатар-Сөүл хотын ах дүүгийн хамтын ажиллагааны хүрээнд, нийслэлийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хүүхэд залуучуудад бие бялдрын болон оюун санааны өв тэгш хүмүүжил олгоход дэмжлэг болох, бүх нийтийн гүйлтийн спортыг хөгжүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Соёл урлагийн газар, Нийслэлийн Биеийн тамир спортын газар, Сөүл хотын соёл мэдээллийн төв, Монголын хөнгөн атлетикийн холбоо хамтран бүх нийтийн гүйлтийн уралдааныг зохион байгуулж байна.

Хоёр. Уралдааны зохион байгуулалт

Уралдааныг Нийслэлийн Биеийн тамир спортын газар, МХАХ-оос томилогдсон шүүгчдийн бүрэлдэхүүн удирдан явуулна.

Уралдаанд 16 наснаас дээш буюу ЕБС-ийн ахлах ангийн сурагчид, Их дээд сургуулиудын оюутан залуучууд оролцоно.

Тамирчид уралдаанд орохоос өмнө эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байна.

Уралдаанд оролцогчдыг 2011 оны 09 дүгээр сарын 24-ны өглөө 09.00-09:30 цагийн хооронд Сүхбаатарын талбай дээр бүртгэнэ.

Уралдаан 10:30 цагаас Сүхбаатарын талбайгаас гараагаа эхэлж Зайсан толгойн танктай хөшөөний өмнө барианд хүрнэ.

Гурав. Шагнал урамшил

Уралдаанд оролцогч тамирчдыг эрэгтэй, эмэгтэй тус бүр эхний 20 байрыг шалгаруулж дараах байдлаар шагнаж урамшуулна.

- ✓ Эрэгтэй, эмэгтэй тус бүр эхний 20 оролцогчийг шагнаж урамшуулна.
- ✓ Идэвхи, зохион байгуулалттай оролцсон баг, хамт олныг бэлэг дурсгалын зүйлээр шагнаж урамшуулна.

Холбоо барих утас: 98119296, 91220618, 96042008